

**«МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУВЬЧЛАЛЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ»-
ийн 2007 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

2008.02.07

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг /ГТХАН/-ээс Голландын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа «МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУВЬЧЛАЛЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ»-ийн 2007 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн үнэлгээ хийхийн зэрэгцээ төслийн 3 дахь шатны үр дүнд үр нөлөөний, үр ашгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төслийн үр дүнг цаашид тогтворжуулахад чиглэсэн санал боловсруулан Сайдын зөвлөлийн хуралдаанд оруулан хэлэлцүүлж шийдвэр гаргуулах.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн Газрын 2006 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 51 дугаар тогтоолоор батлагдсан “*Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам*”-ыг арга зүйн үндэс болгов.

Төслийн 2007 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төслийн дотоод хяналт шинжилгээ үнэлгээний тайлан, 2007 оны гүйцэтгэлийн тайлан, төслийн удирдах хорооны хурлын тэмдэглэлүүд, төсөл хэрэгжиж буй сумдын мал эмнэлгүүдийн эдийн засгийн үзүүлэлтүүдийн судалгааны дүн, 2007 онд зохион байгуулсан сургалтуудын дэлгэрэнгүй тайлан зэрэг материалуудыг уншиж судлан дүн шинжилгээ хийсний зэрэгцээ төслөөс зохион байгуулсан уулзалт ярилцлага, төслийн явцын үр дүнг хэлэлцэх семинар зэрэгт оролцон хэлэлцүүлэг хийсэн болно.

Гурав. Төслийн товч агуулга

3.1. Төслийг хэрэгжүүлэх үндэслэл

Монгол улсын нийгэм, эдийн засгийн харилцааг зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх өөрчлөлтийн хүрээнд мал эмнэлгийн анхан шатны нэгжүүд хувьчлагдсан. Энэ үед мал эмнэлгийн нэгжийг хувьчилж авсан болон шинээр мал эмнэлгийн үйлчилгээний нэгж байгуулж буй малын эмч нар мэргэжлийн мэдлэг, ур чадварын хувьд зохих түвшинд хүрч туршлагажсан байсан хэдий ч зах зээлийн тогтолцоонд хувийн аж ахуй эрхлэх мэдлэг, туршлага нэн хомс байлаа. Үүний зэрэгцээ малчид мал эмнэлгийн үйлчилгээнд төлбөр төлж хамрагдах эдийн засгийн боломж, сэтгэл зүйн бэлтгэл хангалтгүй байв. Эдгээр гол хүчин зүйлүүдийн улмаас мал эмнэлгийн нэгжийн чадавх богино хугацаанд доройтож, үйлчилгээний чанар ихээхэн муудсан юм. Яг ийм цаг үед харилцан уялдаа холбоогүй ганцаарчилсан нэгжүүд болон хувирсан **хувийн мал эмнэлгийн нэгжүүд болон төрийн мал эмнэлгийн байгууллагуудыг чадавхжуулж, малчдын хүсэн хүлээж буй хэрэгцээг хангасан үйлчилгээг хүргэх оновчтой тогтолцоог хамтран бий болгох** зорилгоор 1999 оны 5 дугаар сараас энэхүү төслийг хэрэгжүүлж эхэлжээ.

3.2. Төслийн товч танилцуулга

Мал эмнэлгийн үйлчилгээний хувьчлалыг дэмжих төсөл 1999 оны 5 дугаар сараас 2008 оны 6 дугаар сар хүртэл нийт 9 жил 2 сарын хугацаанд үргэлжилнэ. Уг төсөл 3 үе шаттай хэрэгжиж байгаа. Гурав дахь үе шат нь 2006 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн.

Төслийн нийт өртөг 3.450.000 Евро. Төслийн 1, 2 дугаар шатны үлдэгдэл хөрөнгө дээр Голландын засгийн газраас 897.000 Еврогийн нэмэлт санхүүжилт олгож 3 дахь үе шатанд хэрэгжүүлэхээр сунгасан.

Төслийн 3 дахь үе шатанд Хөвсгөл, Сэлэнгэ, Төв, Баян-Өлгий, Хэнтий, Өвөрхангай, Ховд, Баянхонгор зэрэг 8 аймгийн

- Монголын Алтай-Соёны эко бүс нутгийн биологийн төрөл зүйлийг ард иргэдийн оролцоотойгоор хамгаалах төсөл,

- Бэлчээрийн тогтвортой менежмент төсөл,

- Хан Хэнтийн дархан цаазтай газрын завсрын бүс нутгийн менежмент төсөл,

- Хустайн байгалийн цогцолборт газрын орчны бүсэд тогтвортой амьжиргаа хөгжүүлэх төсөл зэрэг төслүүд хэрэгжиж буй бүс нутагт харьяалагддаг 38 сум хамрагдаж байгаа. Дээрх төслүүдийг НҮБХХ, НЗГ, ГТХАН-ээс санхүүжүүлж байна.

3.3. Төслийн гол үйл ажиллагаа

- Төслийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд урт, богино хугацааны мэргэжилтнээр зөвлөгөө өгүүлэх
- Мэргэжил дээшлүүлэх
- Бага хэмжээний материаллаг дэмжлэг үзүүлэх

3.4. Үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд

- Сонгосон бүс нутаг дахь мал эмнэлгийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ 2005-аас 2008 он хүртэлх хугацаанд 20%-иар өссөн байна.
- Сонгосон бүс нутаг дахь бүлгийн зохион байгуулалттай малчдын мал сүргийн нь эрүүл мэндийн байдал 2005-аас 2008 он хүртэлх хугацаанд мэдэгдэхүйц сайжирсан болох нь нотлогдоно.

3.5. 2007 оны үйл ажиллагааны тойм

Мал үржлийн талаар малчдад өгөх зөвлөмж, Малын эрүүл мэндэд урьдчилан сэргийлэх арга хэмжээний ач холбогдол сэдвүүдээр тус бүр 1 багц үзүүлэн, нугалбарууд, Шувууны томуу, Бэлчээрийн менежмент сэдвүүдээр мөн тус бүр 1 багц үзүүлэн, Хонины цэцэг сэдвээр нугалбар зэргийг шинээр боловсруулан хэвлүүлжээ.

Сумдад ажиллаж буй малчны зөвлөхүүдийг зөвлөгөө өгөх 4 сэдвийн тус бүр 1 багц үзүүлэн, сэдэв тус бүрээр 50 ширхэг нугалбараар хангаж, малчдад зөвлөгөө өгөх ажлыг гүйцэтгүүлэв.

Төсөл хэрэгжиж буй 8 аймгийн малын эмчид зориулсан сургалтыг орон нутагт зохион байгуулж 333 малын эмч хамрагдлаа.

Шинээр сонгогдсон малчны зөвлөхүүдэд зориулан “Насанд хүрэгчдийн сургалтын арга зүй” сэдэвт сургалт зохион байгуулсаны зэрэгцээ Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл аймгийн орон нутгийн хүсэлтийн дагуу зөвлөгөө өгөх арга зүйн талаар хавар, намрын сургалт зохион байгуулсан.

Хэнтий аймагт 27, Өвөрхангай аймагт 6, Баянхонгор аймагт 6, Баян-Өлгий аймагт 7, Ховд аймагт 6 малчны бүлэгт малын эрүүл мэндийг хамгаалах сан байгуулж нийт 47,1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлжээ.

МЭАЦТЛ-д Эпидиомологийн нэгж байгуулсаны зэрэгцээ нэг мэргэжилтнийг

Голланд улсад 45 хоногийн хугацаагаар сургаж мэргэжил дээшлүүсэн байна.

Дөрөв. Үнэлгээ

4.1. Гүйцэтгэлийн үнэлгээ

Төслийн хүрээнд 2007 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2006 оны 10 дугаар сард боловсруулаад 2006 оны 12 сарын 22-ны өдөр хуралдсан удирдах хорооны хурлаар хэлэлцүүлэн батлуулж ажиллажээ. 2007 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд

Үр дүн 1. Төсөлд хамрагдсан сумдын малчдад малын эрүүл мэнд, мал аж ахуй эрхлэх арга ажиллагааны талаар тогтвортой, үр дүнтэй сургалт явуулна,

Үр дүн 2. Төсөлд хамрагдсан сумдын малчдыг малын чанар сайтай эм, тарилгаар хангана,

Үр дүн 3. УМЭАЦТЛ-ийн шүлхий өвчнийг оношлох хүчин чадлыг сайжруулж, боловсон хүчний нөөцийг бэхжүүлнэ,

Үр дүн 4. Төсөлд хамрагдсан аймгийн хувийн мал эмнэлгүүд эдийн засгийн шалгуураар үйлчилгээ үзүүлдэг болсон байна,

Үр дүн 5. Улсын болон хувийн мал эмнэлгийн үйлчилгээний харилцан хамтын ажиллагааг дэмжинэ, гэсэн 5 багц үр дүнд хүрэх зорилт тавьж 33 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тэдгээрээс 25 үйл ажиллагаа бүрэн хэрэгжсэний зэрэгцээ 5 үйл ажиллагаа төлөвлөсөн хэмжээнд хүрч хэрэгжиж чадаагүй байна. Үүнээс гадна 3 үйл ажиллагааг дараа онд хэрэгжүүлэхээр хойшлуулжээ.

2007 оны 12 дугаар сарын 14-ны өдөр хуралдсан Төслийн удирдах хорооны хурлаар тус онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны биелэлтийг хэлэлцэн хангалттай сайн гэсэн үнэлгээ өгсөний зэрэгцээ МЭАЦТЛ-д Эпидемиологийн нэгж байгуулсан, Эмийн эргэлтийн сан нийт 82-ыг байгуулсан, Төслийн үйл ажиллагааны дүнд бэлтгэгдсэн хүний нөөцийг ХААҮШУОНТ-ын харьяалалд шилжүүлэх бэлтгэл ажлыг хэрэгжүүлсэн зэрэг үйл ажиллагааг сайшаан хуралдааны протоколд тэмдэглэсэн байна.

Тухайн онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, ажлын гүйцэтгэлийн талаар бичсэн дэлгэрэнгүй тайлан зэрэг бичиг баримтуудыг үндэслэн “Мал эмнэлгийн үйлчилгээний хувьчлалыг дэмжих төсөл”-ийн 2007 оны гүйцэтгэл **100.0% буюу хангалттай сайн** гэсэн үнэлгээнд тэнцэж байна.

4.2. Үр дүнгийн тогтворжилтын үнэлгээ

Үр дүнгийн тогтворжилтын үнэлгээг хийхдээ 2007 он болон түүнээс өмнөх онуудад хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг уншиж судалсан болно. Он тус бүрт хэрэгжүүлхээр төлөвлөсөн ажлаа хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласны дүнд дараах үр дүнгүүд тогтворжиж эхэлсэн байна.

Малын эрүүл мэндийн талаар малчдад зөвлөгөө өгөх тогтолцоог бүрдүүлж энэхүү үүргийг гүйцэтгэх хүний нөөцийг мэдээллээр хангах, дадлага туршлагыг нэмэгдүүлэх зорилготой сургалтыг дээд болон дунд түвшинд тогтсон хугацаанд зохион байгуулж хэвшсэн байна. Зөвлөхүүдэд зориулсан сургалтыг зохион байгуулахдаа төслийн багийн оролцоог аажмаар багасгах арга механизмыг хэрэглэснээр дунд түвшинд зохион байгуулах сургалтыг орон нутагт бие даан зохион байгуулах бүрэн чадвартай болжээ. Харин дээд түвшинд зохион байгуулах зааварлагч нарын сургалтыг тогтмол зохион байгуулах асуудал өнөөдрийг хүртэл бүрэн шийдэгдэж тогтворжоогүй байна. Зөвлөхүүдийн ажил, зааварлагч нарын ажлаас ихээхэн хамааралтай тул энэ нь төслийн үр дүн цаашид үргэлжлэх боломжгүй байдалд хүргэх сөрөг талтайг төслийн үр

дүнг хүлээж авах талууд зайлшгүй анхаарах шаардлагатай.

Тогтмол сургалтанд хамрагдаж туршлагаа харилцан солилцсон малчдын зөвлөхүүд жилд 2 улирал ажиллаж хэвшсэн бөгөөд ажлын явцад зааварлагчид болон төслийн багаас хяналт тавьж зөвлөгөө өгч байсан нь энэ ажил тодорхой үр дүнд хүрч хэвшил болоход чухал түлхэц болжээ.

Малын эмч нарын эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллага болох Монголын Мал Эмнэлгийн Холбоог бэхжүүлэх талаар хэрэгжүүлсэн ажлууд зохих үр дүнд хүрч МонМЭХ санхүүгийн хувьд ч, сургалт зохион байгуулах материаллаг баазын хувьд ч, ажлын туршлагын хувьд ч бэхжиж төслийн зарим үр дүнг цаашид үргэлжлүүлэх чадвартай, малын эмч нарт мэргэжлийн үйлчилгээ, үзүүлдэг нэр хүнд бүхий байгууллага болсон гэж дүгнэж болохоор байна. 2007 онд МонМЭХ-оос зохион байгуулсан сургалтуудын 80% нь оролцогчдоос **онцсайн** гэсэн үнэлгээгээр дүгнэгдсэн байна.

Төслөөс дэмжиж байгуулсан Малын эрүүл мэндийн сангийн хөрөнгө зориулалтын дагуу сайн ашиглагдаж байна гэсэн дүгнэлт тайланд дурьдагджээ. Гэсэн хэдий ч ашиглалт, үр өгөөжийн талаар хийсэн нарийвчилсан судалгаа хомс байна. Харин эм хангамжийн хоршоодын үйл ажиллагаанд хяналт тавих тогтолцоо бүрдсэн нь цаашид үйл ажиллагаа нь тогтвортой үргэлжлэх бололцоог хангасан гэж үзэж болохоор байна.

МЭАЦТЛ-д Эпидиомологийн нэгж байгуулсан нь Мал эмнэлгийн мэдээ мэдээлэл, зарим судалгааг шинэ шатанд гаргахад чухал үүрэг гүйцэтгэх ажил болсон байна. Шинээр байгуулагдсан энэхүү нэгж нь цаашид тогтвортой ажиллах бололцоогоор хангандсан гэж үзэж байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний хувьчлалыг дэмжих төслийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой бусад төсөл, хөтөлбөрүүдийн удирдлага, ажилтнуудтай уулзалт ярилцлага хийж хамтын ажиллагаа болон үндсэн үзэл баримтлалынхаа талаар санал солилцдог нь төслийн үйл ажиллагааг сайжруулах, улмаар үр дүнг цаашид тогтвортой байлгахад чухал ач холбогдолтой юм. 2007 онд нийт 43 удаагийн уулзалт ярилцлагыг зохион байгуулсан байна.

Дээрх дүгнэлтүүд дээр үндэслэн үр дүнгийн тогтворжилт **80,0% буюу хангалттай** гэсэн үнэлгээтэй байна гэж дүгнэж байна.

4.3. Үр ашгийн үнэлгээ

Төсөл хэрэгжиж буй аймаг, сумдын олонх малчид, нийт хувийн мал эмнэлгийн малын эмч нар бол уг төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны эцсийн үр шимийг хүртэгч хамгийн том бүлгүүд юм.

Төслийн үйл ажиллагааны дүнд малчдад хүргэж буй мал эмнэлгийн үйлчилгээ илүү чанартай болж байгаагийн зэрэгцээ малчид малын өвчний талаар тодорхой мэдлэгтэй болж байгаа. Үүний үр дүнд мал сүргийн өвчнөөс шалтгаалах хорогдол буурч малчдын ашиг, орлого нэмэгдэх учиртай. Малчдын хүртэж буй үр ашгийг нарийвчилсан тоон үзүүлэлтээр тодорхойлох боломжгүй байна. Учир нь Монгол улсын статистикийн тоо мэдээлэл хамгийн багадаа сумын хэмжээнд нэгтгэсэн мэдээлэл байдаг учраас түүнийг ашиглан тооцоо хийх боломжгүй юм. Харин төслийн үр шимийг хүртэж буй малчдаас асуулга авах, тэдний амьдрал ахуйд гарч буй өөрчлөлтийн хандлагыг ажиглах аргаар судалгаа хийсэн тайлан, материалууд цөөнгүй байгаа. Жишээлбэл, Төв аймгийн зарим сумдад төлийн хорогдол 80%-иар буурсан гэж мэдээллэсэн байна. Судалгаанд хамрагдсан малчдын 90 гаруй хувь нь зөвлөгч нарын өгсөн зөвлөгөөг амьдрал ахуйдаа хэрэгжүүлнэ гэдгээ илэрхийлсэн байна. Тэдгээрээс харахад малчдад уг төслийн үйл ажиллагаа үр өгөөжөө өгч малчдын ашиг, орлого нэмэгдэж байгаа нь тодорхой байна.

Харин малын эмч нарын хувьд зарим материаллаг дэмжлэг авсаны зэрэгцээ зах зээлийн нөхцөлд аж ахуйн нэгжийг эрхлэх талаар тодорхой мэдлэгтэй болж хоцорч

байгаа. Үүнээс гадна мал эмнэлгийн үйлчилгээний ач холбогдол, үнэ цэнийн талаар олонх малчид зөв ойлголттой болж байгаа тул мал эмнэлгийн үйлчилгээг хүртэх, улмаар төлбөрөө хугацаанд нь төлөх сонирхол бий болж байгаа. Энэ нь хувийн мал эмнэлгийн ашиг, орлого нэмэгдэх чухал хөшүүрэг юм. 2007 оны эхэнд 50 хувийн мал эмнэлгийг хамруулан судалсан судалгаанаас харахад малчдаас төлбөрийг нь төлдөг эмчилгээ үйлчилгээний тоо 20%-иар нэмэгдсэн гэсэн дүн гарсан байна. Үүний үр дүнд хувийн мал эмнэлгүүдийн орлого дунджаар 13%-иар нэмэгджээ. Гэсэн хэдий ч Хөвсгөл, Хэнтий зэрэг аймагт зарим хувийн мал эмнэлгүүдийн орлого буурсан судалгаа байгааг тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Эм хангамжийн хоршоодын борлуулалт тогтворжиж, үр ашгаа өгч эхэлсэн байна. Тухайлбал, ийм эх үүсвэртэй хөрөнгөөс МонМЭХ 2007 онд хувийн мал эмнэлгүүдийг дэмжих чиглэлээр 30.7 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна.

Уг төслийн хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажилгааны үр ашгийн судалгаанд эдийн засгийн нарийн арга зүй ашиглаж хийсэн судалгаа хомс байгаа нь харагдаж байгаа. Энэхүү төслийн үйл ажиллагааны үр ашгийн үнэлгээ **85.0 % буюу хангалттай** гэсэн үнэлгээтэй байна.

4.4. Үр нөлөөний үнэлгээ

Бодлого тодорхойлох удирдлагын түвшинд нөлөөлөл үзүүлж тулгамдсан зарим асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор дугуй ширээний ярилцлага 4 удаа зохион байгуулсан байна.

- Мал, амьтны шилжилт хөдөлгөөн, хорио цээрийн хяналт, ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээ, мал эмнэлгийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ сэдвээр зохион байгуулсан дугуй ширээний ярилцлагад ХХААЯ-2, ХЗДХЯ-1, УМХГ-9, аймгуудын МЭА-10, Хүнсний захын малын эмч-2, ХААИС-2, МонМЭХ-2 нийт 28 хүн оролцож УМХГ-т 3 асуудлыг, ХХААЯ-нд 2 асуудлыг зөвлөмж болгосон байна.
- Төсөл дууссаны дараа малчдад зөвлөгөө өгөх ажлыг тогтвортой үргэлжлүүлэх арга зам сэдвээр зохион байгуулсан дугуй ширээний ярилцлагад ХХААЯ-2, ХААҮШУОНТ-2, аймгуудын ХААНТ-5, орон нутгийн малын эмч-2, ХААИС-2, хамтран ажилладаг төсөл хөтөлбөрүүд-3 нийт 16 хүн оролцож ХААҮШУОНТ-д 1, аймгуудын ХААНТ-д 2 асуудлыг зөвлөмж болгосон байна.
- Хувийн мал эмнэлгүүдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр сэдвээр дугуй ширээний ярилцлага зохион байгуулж 5 гол асуудалд анхаарлаа төвлөрүүлэх шаардлагатай гэж үзэж уг асуудлыг яамны удирдлагад танилцуулахаар бэлтгэж байна.
- Малын эмч нарт итгэмжлэл олгох сургалтын зохион байгуулалтын асуудал сэдвээр зохион байгуулсан дугуй ширээний ярилцлагад ХХААЯ-2, ХААИС-3, МонМЭХ-2, МЭАЦТЛ-1 нийт 8 хүн оролцож 3 гол асуудлаар нэгдсэн шүийдэлд хүрсэн байна.

Шинэ гарын авлага, материалаар хангагдсан зөвлөхүүд 2007 онд ажлын 2 улиралд 7808 малчин өрхөд хүрч ажиллан малын эрүүл мэндийн талаар зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлжээ. Малчдад зөвлөгөө өгөх ажлын үр нөлөөг үнэлж дүгнэхийн тулд төсөл хэрэгжүүлэх багаас Мянганы хөгжлийн зорилтод уг төслөөс оруулах хувь нэмрийг тусгасан асуулгын хуудас боловруулж 114 малчин өрхийг хамруулан судалгаа хийж байна. Эхний судалгааны үр дүнгээс харахад хувийн мал эмнэлгийн төлбөрт үйлчилгээний талаар малчдад үзэл бодлын эргэлт гарч малчин, малын эмч нарын хоорондын харилцаа сайжран төслийн хүрсэн үр дүнгийн тогтвортой үргэлжлэх явдлыг хангах гол хүчин зүйл болж чадсан байна.

Малчид төдийгүй малын эмч нарын үзэл бодолд эргэлт гаргаж зах зээлийн

нөхцөлд өрсөлдөөний зарчимаар аж ахуй эрхлэх ойлголт, бие дааж ажиллах хүсэл эрмэлзэлийг төрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байгаа. Гэсэн хэдий ч малын эмч нарын талаас илүү хувь нь зөвхөн төрөөс олгож буй үйлчилгээний хөлсөнд дулдуйдан аж ахуй эрхэлж байна. Өөрөөр хэлбэл малчдад хүргэж буй үйлчилгээгээ чанаржуулах, чанар дагуулж үйлчилгээнийхээ үнэ хөлсийг нэмэгдүүлэх, үйлчилгээнийхээ нэр төрлийг олшруулах талаар санаачлага гаргахгүй байна гэсэн үг.

Малын эмч нар уг төслөөс хэрэгжүүлж байгаа малын эрүүл мэндийн зөвлөгөө өгөх үйлчилгээг эерэгээр хүлээж авч байгаа. Энэ үйлчилгээний ач холбогдол, нөлөөллийн талаар 24 малын эмчээс судалгаа авчээ. Тэдний 20 нь зөвлөгөө өгч байгаа арга хэмжээ өөрсдийнх нь ажилд дэмжлэг болж байгаа гэж дүгнэсэн байна.

Төслийн үйл ажиллагааны үр нөлөөний үнэлгээ **80.0% буюу хангалттай** гэсэн үнэлгээтэй байна.

№	Хүрэх үр дүн	Хувь	Оноо
1	Гүйцэтгэлийн үнэлгээ	100.0	5.0
2	Үр дүнгийн тогтворжилтын үнэлгээ	80.0	4.0
3	Үр ашгийн үнэлгээ .	85.0	4.25
4	Үр нөлөөний үнэлгээ	80.0	4.0
ЕРӨНХИЙ ДҮН		86.25	4.31

«Мал эмнэлгийн үйлчилгээний хувьчлалыг дэмжих төсөл»-ийн үйл ажиллагаанд хүлээгдэж буй үр дүнгийн болон тогтворжилтын үнэлгээнүүдийг хийж **“ХАНГАЛТТАЙ”** гэсэн үнэлгээ өгч байна.

Тав. Дүгнэлт

- Малын эрүүл мэндийн зөвлөгөө өгөх үйлчилгээг иж бүрэн тогтолцоогоор шийдвэрлэсэн нь мал эмнэлгийн салбарт төдийгүй хөдөө аж ахуйн экстейншиний орон нутагт үзүүлэх үйлчилгээнд томоохон хувь нэмэр оруулсан байна.
- Малын эрүүл мэндийн асуудлаар малчдад зөвлөгөө өгөхөд зориулж боловсруулсан гарын авлага материалуудын электрон хувийг ХААҮШҮОНТ-д шилжүүлэн өгсөн нь цаашид хэвлэн олшруулах, түгээх замаар төслийн үр дүнг цаашид үргэлжлүүлэх бололцоог хангасан чухал ач холбогдолтой ажил болжээ.
- Хөндлөнгийн хяналт-шинжилгээ үнэлгээнээс гадна дотоод хяналт-шинжилгээний олон арга хэлбэрүүдийг хослуулан хэрэглэж хэвшсэн нь төслийг үр дүнтэй хэрэгжих бололцоогоор хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзэж байна.
- FAO, Европийн холбоо, Дэлхийн байгаль хмагаалах сан зэрэг олон хандивлагчид тус төслөөс боловсруулсан зөвлөгөө өгөх загвар, зөвлөгөө өгөхөд зориулж боловсруулсан материалуудыг өөрсдийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нь малын эрүүл мэндийн зөвлөгөө өгөх тогтолцоо нэлээд оновчтой зөв хувилбараар боловсруулагдсан болохыг илэрхийлж байна.

Зургаа. Санал, зөвлөмж

- Аймгийн түвшинд ажиллах зааварлагчдын ажлыг цаашид үргэлжлүүлэх зохистой хувилбарыг олж төсөл дуусахаас өмнө зарим ажлыг эхлүүлэн турших талаар төслийн баг илүү анхаарал тавьж төслийн үр дүнг хүлээж авах талуудтай идэвхтэй хамтран ажиллах хэрэгтэй байна.
- Төсөл хэрэгжиж буй сумдын мал эмнэлгийн эдийн засгийн үзүүлэлтүүдийг тухайн аймгийн төслийн бус сумдын үзүүлэлтүүдтэй харьцуулан дүгнэж үр ашгийг илүү бодитой тооцоолон гаргах хэрэгтэй.
- Эмийн эргэлтийн сангийн ашиглалт, үр өгөөжийг сайжруулах зорилгоор нарийвчилсан судалгаа хийж хяналтыг тогтолцоог боловсронгуй болгоход анхаарлаа хандуулж ажиллах шаардлагатай байна.
- Төслийн орон нутаг дахь зохицуулагчдын ажилд хэрхэн хяналт тавьдаг, хэрхэн үнэлгээ хийдэг талаар дурьдагдсан зүйл тайланд хомс байгааг анхаарах хэрэгтэй.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ ХИЙСЭН:

ХХААЯ-ны МХШҮГ-ын мэргэжилтэн:

С.Дивангар

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

ХХААЯ-ны МХШҮГ-ын дарга:

Д.Бат-Эрдэнэ